



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/271

Есөнбулаг сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 64 дүгээр тогтоол, Үнэлгээний хорооны 2026 оны 05 дүгээр сарын 12-ны өдрийн 521 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААХААГ/20260102035 дугаартай Багийн дарга нарыг компьютержуулах ажлыг "Стэппэ вэйв энерги" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т олгосугай.

2. Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Я.Жаргалцэцэг) Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

